

# ЕВРОПЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ОРОН ЗАЙН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛЛЫН СТАНДАРТ БА ЗААВАР ЗӨВЛӨГӨӨ

*/2015 онд шинэчлэн баталсан хувилбар/*

Чанарын баталгаажуулалтын стандартууд дараах гурван бүлэгт хуваагдана. Үүнд:

- Чанарын дотоод баталгаажуулалт /ЧДБ/
- Чанарын хөндлөнгийн баталгаажуулалт /ЧХБ/
- Чанарын баталгаажуулалтын байгууллага /ЧББ/

Эдгээр гурван бүлэг өөр хоорондоо нягт харилцан уялдахаас гадна бүхэлдээ Европын чанарын баталгаажуулалтын тогтолцоо /ЕЧБТ/-ны суурийг бүрдүүлдэг. 2 дугаар бүлэг дэх ЧХБ нь 1 дүгээр бүлэг дэх ЧДБ-ын стандартыг хүлээн зөвшөөрдөг тул ЧХБ-тай шууд холбоотойгоор сургуулийн хэрэгжүүлж буй дотоод ажлыг баталгаажуулдаг юм. Үүнтэй адилаар 3 дугаар бүлэг, 2 дугаар бүлэг хоорондоо харилцан уялдана. Иймд эдгээр гурван бүлэг стандарт нь дээд боловсролын сургалтын байгууллага /ДБСБ/ түүнчлэн ЧББ-д харилцан нөхөж үйлчлэх бөгөөд чанарын баталгаажуулалтын тогтолцоонд оролцогч талууд бүгд хувь нэмрээ оруулдаг гэсэн ойлголцол дээр тулгуурлана. Иймээс эдгээр гурван бүлэг стандартуудыг бүхэлд нь уншиж ойлгох хэрэгтэй.

Эдгээр стандартууд нь Европын дээд боловсролын орон зай /ЕДБО/ дахь дээд боловсролын чанарын баталгаажуулалтын харилцан хүлээн зөвшөөрсөн, тохирсон практикыг тогтоосон учраас дээд боловсролын бүхий л үйлчилгээ, түүнд холбогдох бүх хүмүүс анхаарч, дагаж мөрдөх ёстой. Хялбар сануулахын тулд стандартуудын хураангуй жагсаалтыг нэгтгэн хавсаргав.

Заавар зөвлөгөөнд стандарт яагаад чухал болохыг, мөн стандарт хэрхэн хэрэгжихийг тайлбарласан болно. Заавар зөвлөгөөнд чанарын баталгаажуулалтанд оролцогч талуудын тухайн оройн зайд хэрэгжүүлсэн сайн туршлагыг анхаарч нэвтрүүлсэн. Нөхцөл байдлаас хамаарч хэрэгжилт нь өөр өөр байж болно.

## 1 ДҮГЭЭР БҮЛЭГ:

### ЧАНАРЫН ДОТООД БАТАЛГААЖУУЛАЛТЫН СТАНДАРТ БА ЗААВАР ЗӨВЛӨГӨӨ

#### 1.1 Чанарын баталгаажуулалтын бодлого

*Стандарт:*

Дээд боловсролын сургалтын байгууллага нь стратеги удирдлагынхаа нэг хэсэг болох чанарын баталгаажуулалтын бодлоготой, түүнийгээ олон нийтэд мэдээлдэг байна. Дотоод оролцогч талууд зохих бүтэц, үйл явцаар дамжуулан энэхүү бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцдог байхаас гадна хөндлөнгийн оролцогч талуудын оролцоог хангадаг байна.

*Заавар зөвлөгөө:*

Бодлого, үйл явц нь ДБСБ-ын чанарын баталгаажуулалтын харилцан уялдаатай тогтолцооны гол тулгуур нь бөгөөд байнгын сайжруулалт хийх мөчлөгийг тодорхойлж, хариуцлагыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. Мөн сургуулийн бүхий л түвшний чанарын баталгаажуулалтад оролцох, чанарын хариуцлагатай байхыг дотоод оролцогч талууд ухамсарлах, чанарын соёлыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Үүний тулд бодлого нь албан ёсоор батлагдаж, олон нийтэд ил тод болсон байна.

Багшлахуй, суралцахуй болон судалгаа шинжилгээний харилцан хамаарлыг чухалчилсан чанарын баталгаажуулалтын бодлого нь илүү үр дүнтэй ба тухайн ДБСБ-ын хувьд үйл ажиллагаа явуулж буй үндэсний хэмжээний болон сургуулийн нөхцөл байдал, стратегийн чиг хандлагыг аль алиныг харгалзан үздэг. Ийм бодлого нь дараах хүчин зүйлсийг дэмждэг. Үүнд:

- Чанарын баталгаажуулалтын тогтолцооны зохион байгуулалт
- Алба, хэлтэс, сургууль, тэнхим болон сургуулийн бусад бүтцийн нэгжүүд, түүнчлэн манлайлагч, багш ажилтан, оюутан гэх мэт чанарын баталгаажуулалтанд үүрэг хариуцлага хүлээгчид
- Академик эрх чөлөө, нэгдмэл байдал болон академик залилан луйвраас сэрэмжлэх
- Багш, ажилтан, оюутныг ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхах болон үл тэвчихийн эсрэг сэрэмжлэх
- Чанарын баталгаажуулалтанд хөндлөнгийн талуудын оролцоо

Сургууль даяар оролцоог хангасан чанарын дотоод баталгаажуулалтын олон төрлийн үйл явцаар энэхүү бодлого хэрэгждэг.

Чанарын баталгаажуулалтын бодлого нь гэрээгээр туслан гүйцэтгэх болон хамтрагч талуудаас гүйцэтгэж буй сургуулийн үйл ажиллагааг мөн адил хамарсан байна.

## **1.2 Хөтөлбөр боловсруулах ба батлах**

*Стандарт:*

Дээд боловсролын сургалтын байгууллага нь хөтөлбөр боловсруулах, батлах үйл явцтай байна. Хөтөлбөрийг суралцахуйн зорилтот үр дүнг агуулан тодорхойлсон зорилгод нийцэхүйц боловсруулах шаардлагатай. Хөтөлбөрийн үр дүнд эзэмших мэргэшлийг тодорхой заасан, тэр нь дээд боловсролын мэргэшлийн үндэсний хүрээ, мөн Европын дээд боловсролын оройн зайн боловсролын мэргэшлийн хүрээний зохих төвшинд нийцсэн, харилцан уялдсан байна.

*Заавар зөвлөгөө:*

Сургалтын хөтөлбөр нь ДБСБ-ын багшлахуйн эрхэм зорилгын үндсэн цөм байна. Хөтөлбөр нь оюутнуудад ирээдүйн ажил мэргэжилд хэрэглэгдэх, хувь хүний хөгжилд нөлөө үзүүлэх хөрвөх болон академик мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ.

Хөтөлбөр нь:

- Сургуулийн эрхэм зорилготой уялдуулан хөтөлбөрийн ерөнхий зорилго, суралцахуйн зорилтот үр дүнг тодорхой илэрхийлсэн байна.
- Хөтөлбөрийг боловсруулахдаа оюутан, бусад оролцогч талуудыг оролцуулсан байна.
- Хөндлөнгийн шинжилгээ болон жишиг шалгуурыг ашигласан байна.
- Европын зөвлөлийн дээд боловсролын 4 зорилгыг тусгасан байна.
- Суралцагчийн хөгжлийг жигд хангахаар боловсруулсан байна.
- Европын кредит шилжүүлэх, хуримтлуулах тогтолцоонд нийцүүлэн суралцагчийн зохист ачааллыг урьдчилан тодорхойлсон байна.
- Танхимын бус сургалт /дадлага, дагалдах г.м /-ыг сайтар хэрэгжүүлэх боломжтой байна.
- Сургуулийн хөтөлбөр батлах албан үйл явцын дагуу батлагдсан байна.

## **1.3 Суралцагч төвтэй суралцахуй, багшлахуй ба үнэлгээ**

*Стандарт:*

Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцахуйн үйл явцад суралцагчийн идэвхитэй оролцоог дэмжих арга замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх бөгөөд суралцагчийн үнэлгээ нь мөн ижил хандлагатай байна.

*Заавар зөвлөгөө:*

Суралцагч төвтэй суралцахуй, багшлахуй нь суралцагчийн сэдэл тэмүүлэл, өөртөө дүн шинжилгээ хийх, оролцоог идэвхижүүлэхэд чухал үүрэгтэй. Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, мөн суралцахуйн үр дүнг үнэлэхдээ үүнийг чухалчилж анхаарна.

Суралцагч төвтэй суралцахуй, багшлахуйн хэрэгжилт нь:

- Суралцагчийн өвөрмөц онцлог, хэрэгцээ шаардлагыг хүндэтгэн сургалтын уян хатан арга замаар суралцах боломж олгоно .
- Шаардлагатай бол янз бүрийн сургалтын хэлбэрээр хэрэгжүүлнэ.
- Сурган хүмүүжүүлэх олон төрлийг аргыг уян хатан ашиглана.
- Сургалтын хэлбэр, сурган хүмүүжүүлэх аргыг тогтмол үнэлж, нийцүүлнэ.
- Багшийн зүгээс зохих заавар зөвлөгөө, дэмжлэг өгөхдөө суралцагчийн бие даасан байдлыг дэмжинэ.
- Суралцагч ба багшийн харилцаанд харилцан хүндэтгэлийг дэмжинэ.
- Суралцагчийн санал гомдлыг шийдвэрлэх журамтай байна.

Суралцагчийн ахиц дэвшил, тэдний ирээдүйн амжилтанд үнэлгээний ач холбогдлыг харгалзан чанарын баталгаажуулалтын үйл явц нь дараах зүйлсийг анхаарч авч үзнэ. Үүнд:

- Шинжээчид нь одоо хэрэгжиж буй үнэлэх, магадлан шинжлэх аргын мэдлэгтэй, энэ чиглэлээр өөрийн ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг авдаг байна.
- Үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлал болон дүнгийн шалгуурыг урьдчилан мэдээлсэн байна.
- Үнэлгээ нь суралцахуйн зорилтот үр дүнд ямар хэмжээнд хүрснээ илэрхийлэх боломжийг суралцагчид олгосон байна. Үнэлгээний талаар суралцагч санал хүсэлтээ илэрхийлдэг, шаардлагатай тохиолдолд сургалтын үйл явцад өгөх зөвлөмжид оруулдаг байна.
- Үнэлгээг аль болох нэгээс дээш шинжээч хийхийг зорино.
- Үнэлгээний журамд хөнгөрүүлэх, зөөлрүүлэх нөхцлийг анхаарч авч үзсэн байна.
- Үнэлгээ нь тогтоосон журмын дагуу бүх суралцагчдын хувьд шударга, тууштай хийгдэнэ.
- Суралцагчийн санал гомдлыг хүлээх авах албан ёсны журамтай байна.

#### **1.4 Суралцагч элсэх, ахиж дэвших, хүлээн зөвшөөрөгдөх, гэрчилгээ авах**

*Стандарт:*

Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн “амьдралын мөчлөг”-ийн бүх үе шат /элсэх, ахиж дэвших, хүлээн зөвшөөрөх, гэрчилгээ авах г.м./-ыг хамруулсан урьдчилан тодорхойлж, мэдээлсэн журмуудыг байнга дагаж мөрдөнө.

*Заавар зөвлөгөө:*

Суралцагчийн академик ахиц дэвшилд шаардлагатай нөхцөл, дэмжлэгийг хангах нь суралцагч, хөтөлбөр, сургууль, боловсролын салбарын тэргүүн сонирхол байдаг. Зорилгоо

эрхэмлэн элсэх, хүлээн зөвшөөрөх, төгсөх журамтай байх нь ялангуяа суралцагч дээд боловсролын салбартаа шилжин суралцах тохиолдолд туйлын чухал юм.

Элсэлтийн бодлого, үйл явц, шалгуурыг ил тод, тууштай хэрэгжүүлдэг байх нь нэн чухал юм. Эдгээрийг сургууль, хөтөлбөрт танилцуулж, зааварчилсан байна.

Сургууль нь суралцагчийн ахиц дэвшлийн мэдээллийг цуглуулах, хянан шинжлэх, мэдээлэх арга хэрэгсэл, үйл явцтай байна.

Дээд боловсролын зэрэг, суралцах хугацаа, өмнөх сургалт, мөн албан бус сургалтыг шударгаар хүлээн зөвшөөрөх нь суралцагч ахиж дэвших, шилжин суралцахыг дэмжих чухал хэсэг юм. Хүлээн зөвшөөрөх журам нь дараах зүйлс дээр үндэслэх нь зүйтэй. Үүнд:

- Лисбоны хүлээн зөвшөөрөх тухай конвенцийн зарчмуудтай нийцүүлсэн тухайн сургуулийн практик
- Бусад сургууль, ЧББ, тухайн улсын хүрээнд хүлээн зөвшөөрөх үйл явцыг хэрэгжүүлдэг үндэсний ENIC/NARIC төвийн хамтын ажиллагаа

Төгсөлт нь суралцагчийн суралцах үеийн төгсгөл юм. Суралцагч нь эзэмшсэн чадамж, суралцахуйн хүрсэн үр дүн, сургалтын агуулга, төвшин, статус зэрэг амжилттай дүүргэж, төгссөнийг тайлбарласан баримт бичгийг хүлээн авна.

## 1.5 Багшлах бүрэлдэхүүн

*Стандарт:*

Дээд боловсролын сургалтын байгууллага нь багш нарынхаа чадамжийг өөрөө баталгаажуулна. Багшийг сонгон шалгаруулж ажилд авах, хөгжүүлэх үйл явц нь шударга, ил тод байна.

*Заавар зөвлөгөө:*

Суралцагч нь мэдлэг, ур чадвар, чадамж эзэмших, арвин туршлагыг чанартай хуримтлуулахад багшийн гүйцэтгэх үүрэг чухал юм. Оюутнуудын олон янз байдал, тэдний суралцахуйн үр дүнд онцгой анхаарал хандуулах нь суралцагч төвтэй суралцахуй, багшлахуйг шаардаж байгаа бөгөөд үүнийг даган багшийн үүрэг өөрчлөгдөж байна (Стандарт 1.3-аас үзэх).

Багш, ажилтны чанар, мөн тэднийг үр бүтээлтэй ажиллах боломж, дэмжлэг бүхий орчин нөхцлөөр хангахад сургууль онцгой үүрэг хүлээнэ. Энэ орчин нөхцөл нь:

- Багш, ажилтныг сонгон шалгаруулж авах ил тод, шударга журмыг дагаж мөрддөг, багшлахуйн ач холбогдлыг хүлээн зөвшөөрөхүйц ажил эрхлэлтийн орчин нөхцлийг бүрдүүлдэг байна.
- Багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжиж, боломжийг бүрдүүлдэг байна.
- Боловсрол сургалт ба судалгаа шинжилгээний хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх эрдмийн үйл ажиллагааг урамшуулж дэмждэг байна.
- Багшлах аргазүйн инноваци, шинэ технологийн хэрэглээг дэмждэг байна.

## 1.6 Суралцахуйн нөөц ба суралцагчийн дэмжлэг

*Стандарт:*

Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцахуй болон багшлахуйн ажилд зориулсан санхүүжилт, суралцахуйн хангалттай, хүртээмжтэй нөөцтэй байх ба оюутныг дэмждэг байна.

### *Заавар зөвлөгөө:*

Дээд боловсролын сайн туршлагаас харахад сургууль нь оюутны суралцахуйд дэмжлэг үзүүлэх олон төрлийн нөөцтэй байдаг. Эдгээр нь номын сан, сургалтын материаллаг бааз хэрэгсэл, болон багш, зөвлөгч, зөвлөх гэх мэт хүн хүчний нөөцийг дэмжих мэдээлэл технологийн дэд бүтэц гэх мэт олон ялгаатай. Дэмжих үйлчилгээ нь сургууль дотроо болон бусад сургуулиудад суралцагч шилжин суралцах үйл явцыг хөнгөвчлөхөд чухал үүрэгтэй.

Оюутны олон янз байдал (жишээ нь: өдөр, орой, эчнээ суралцдаг, ажил эрхэлдэг, гадаадын, хөгжлийн бэрхшээлтэй г.м.)-ын хэрэгцээ шаардлага, суралцагч төвтэй сургалт, суралцахуй, багшлахуйн уян хатан хэлбэр зэргийг суралцагчийн дэмжлэг, суралцахуйн нөөцийг хуваарилах, төлөвлөх, хангахад анхаарч тооцох шаардлагатай болдог.

Сургуулийн онцлогоос хамааран оюутныг дэмжих үйл ажиллагаа, сургалтын материаллаг бааз хэрэгслийг янз бүрээр зохион байгуулж болно. Гэхдээ ЧДБ нь эдгээр нөөц нь зорилгод нийцэж буй эсэх, хүртээмжтэй эсэх, оюутнууд тэдэнд зориулсан үйлчилгээний талаарх мэдээллээр хангагдсан эсэхийг баталгаажуулдаг байна.

Дэмжих үйлчилгээг үзүүлэхэд удирдах ба үйлчилгээний ажилтны үүрэг нэн чухал учраас тэд энэ талаар мэргэжсэн байхаас гадна чадамжаа хөгжүүлэх боломжтой байх ёстой.

## **1.7 Мэдээллийн удирдлага**

### *Стандарт:*

Дээд боловсролын сургалтын байгууллага өөрийн хөтөлбөр, бусад үйл ажиллагааг үр дүнтэй удирдахын тулд холбогдох мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, ашиглах боломжийг хангасан байна.

### *Заавар зөвлөгөө:*

Үнэн зөв, баталгаатай өгөгдөл нь шийдвэр гаргах, юу сайн ажиллаж байгаа, юунд анхаарал хандуулах шаардлагатайг олж мэдэхэд нэн чухал юм. Сургалтын хөтөлбөр болон бусад үйл ажиллагааны мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх нь ЧДБ-ын тогтолцоог тэтгэж өгдөг.

Цуглуулсан мэдээлэл нь зарим талаараа сургуулийн төрөл, эрхэм зорилгоос хамаарах боловч дараах хэлбэртэй байж болно. Үүнд:

- Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд
- Суралцагчийн намтар
- Суралцагчийн ахиц дэвшил, сурлагын амжилт, сургууль завсардалтын түвшин
- Хөтөлбөрийн талаарх суралцагчийн сэтгэл ханамж
- Суралцахуйн нөөц, суралцагчийн дэмжлэг
- Төгсөгчдийн ажил эрхлэлт

Мэдээллийг янз бүрийн аргаар цуглуулж болно. Мэдээллийг цуглуулах үйл ажиллагааг төлөвлөх, дүн шинжилгээ хийх, мэдээлэхэд багш, суралцагч оролцох нь чухал.

## **1.8 Олон нийтийн мэдээлэл**

### *Стандарт:*

Дээд боловсролын сургалтын байгууллага нь хөтөлбөр, бусад үйл ажиллагааны

мэдээллийг хэвлэн түгээдэг байна. Мэдээлэл нь тодорхой, үнэн зөв, бодитой байх ба олж авахад хялбар, байнга шинэчлэгддэг байна.

*Заавар зөвлөгөө:*

Сургуулийн үйл ажиллагааны мэдээлэл нь элсэн орох гэж байгаа болон суралцаж байгаа оюутнууд, төгсөгчид, бусад оролцогч талууд, олон нийтэд хэрэгтэй. Тиймээс сургууль санал болгож буй хөтөлбөрүүд, тэдгээрийг сонгох шалгуурууд, хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, төгсөх буюу боловсролын зэрэг олгох, суралцахуйн болон багшлахуйн үйл явц, үнэлгээний журам, сурлагын амжилтын хувь, суралцагчдад олгох боломж, мөн төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтэнд чиглэсэн мэдээллээр хангадаг байна.

### **1.9 Хөтөлбөрийн байнгын хяналт-шинжилгээ болон үечилсэн үнэлгээ**

*Стандарт:*

Хөтөлбөрүүд нь тодорхойлсон зорилгодоо хүрэх, суралцагч болон нийгмийн хэрэгцээг хангахын тулд сургууль нь хяналт-шинжилгээ, үечилсэн үнэлгээ хийдэг байна. Шинжилгээ, үнэлгээ нь хөтөлбөрүүдийг тасралтгүй сайжруулахад чиглэнэ. Үүнтэй холбоотой төлөвлөсөн үйл ажиллагаа болон хүрсэн үр дүн нь холбогдох бүх талууд, хүмүүст мэдээлэгддэг байна.

*Заавар зөвлөгөө:*

Сургалтын хөтөлбөрийг байнга хянан шинжилж, үнэлж, сайжруулах зорилго нь суралцагчид таатай нөхцлийг бүрдүүлэх, хадгалах, суралцахуйг дэмжихэд үр нөлөөтэй орчинг бүрдүүлэхэд оршино. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд дараах зүйлс хамаарна. Үүнд:

- Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн салбарын сүүлийн үеийн судалгаа, цаг үетэй нийцэж шинэчлэгдсэн байдал
- Нийгмийн эрэлт хэрэгцээний өөрчлөлт
- Суралцагчийн ачаалал, ахиц дэвшил, дүүргэлт
- Суралцагчийн үнэлгээний журмын үр өгөөж
- Хөтөлбөртэй холбоотой оюутны хүлээлт, эрэлт хэрэгцээ, сэтгэл ханамж
- Суралцахуйн орчин, дэмжих үйлчилгээ ба тэдгээрийн хөтөлбөрийн зорилгод нийцсэн байдал

Суралцагч болон бусад сонирхогч талуудыг хөтөлбөрийг үнэлэх, сайжруулахад тогтмол оролцуулна. Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хөтөлбөрийг шинэчлэх нь цаг үетэй нийцсэн байна. Сайжруулсан хөтөлбөрийн тодорхойлолтыг мэдээлдэг байна.

### **1.10 Чанарын хөндлөнгийн давтамжит баталгаажуулалт**

*Стандарт:*

Дээд боловсролын сургалтын байгууллага нь энэхүү ЧБСЗЗ-д нийцүүлэн чанарын хөндлөнгийн баталгаажуулалтыг давтамжит байдлаар хийлгэнэ.

*Заавар зөвлөгөө:*

ЧХБ янз бүрийн хэлбэртэй байвч сургуулийн ЧДБ-ын үр өгөөжийг магадлан, сургуулийн сайжруулалтыг хурдасган, шинэ хэтийн төлвийг дэвшүүлдэг. Мөн сургуулийн үйл ажиллагааны чанарын талаарх мэдээллийг сургууль болон олон нийтэд хүргэдэг.

Сургууль нь үйл ажиллагаагаа явуулж буй хууль эрх зүйн шаардлагад нийцүүлэн, ЧХБ-ыг давтамжтайгаар хийлгэнэ. Хууль эрх зүйн хүрээнээс хамааран ЧХБ нь олон хэлбэртэй байхаас гадна сургуулийн өөр өөр төвшин (жишээ нь хөтөлбөр, багш, сургууль г.м.)-д төвлөрч хийгдэнэ.

Чанарын баталгаажуулалт нь хөндлөнгийн санал дүгнэлт, тайлан, түүний дагуу засан сайжруулах үйл явцаар дуусахгүй байнгын үйл ажиллагаа байна.

## 2 ДУГААР БҮЛЭГ.

### ЧАНАРЫН ХӨНДЛӨНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН СТАНДАРТ БА ЗААВАР ЗӨВЛӨГӨӨ

#### 2.1 Чанарын дотоод баталгаажуулалтыг чухалчлах

*Стандарт:*

Чанарын хөндлөнгийн баталгаажуулалт нь энэхүү ЧБСЗЗ-ийн 1 дүгээр бүлэгт заасан чанарын дотоод баталгаажуулалтын үр өгөөжийг авч үздэг байна.

*Заавар зөвлөгөө:*

Дээд боловсролын чанарын баталгаажуулалт нь хөтөлбөр болон бусад үйлчилгээнийхээ чанарт хүлээх сургуулийн үүрэг хариуцлагад үндэслэдэг. Иймд ЧХБ нь чанарыг баталгаажуулах сургуулийн үүрэг хариуцлагыг дэмжин хүлээн зөвшөөрч байх нь чухал юм. ЧДБ болон ЧХБ-ыг харилцан уялдуулахын тулд ЧХБ нь 1 дүгээр бүлгийн стандартуудыг чухалчилдаг байна. ЧХБ-ын төрөл, онцлогоос хамааран стандартуудыг харилцан адилгүй байдлаар авч үзэж болно.

#### 2.2 Зорилгод нийцсэн арга зүйг боловсруулах

*Стандарт:*

Зорилго, зорилтдоо хүрэх боломжийг хангахаар холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн чанарын хөндлөнгийн баталгаажуулалтыг тодорхойлж, боловсруулсан байна. Ийнхүү боловсруулах, тасралтгүй сайжруулахад оролцогч талууд оролцдог байна.

*Заавар зөвлөгөө:*

ЧХБ нь бодитой, үр өгөөжтэй байхын тулд оролцогч талууд хүлээн зөвшөөрсөн тодорхой зорилготой байх нь чухал юм. Энэ зорилго, түүний хэрэгжилт нь:

- ДБСБ-д очих ачаалал, өртгийг тооцох
- Чанарыг сайжруулахад сургуулийг дэмжих хэрэгцээг анхаарах
- Чанарын сайжруулалтаа харуулах боломжийг сургуульд олгох
- Үр дүн болон авах арга хэмжээний тухай тодорхой мэдээлэх

Сургууль өөрийн ЧДБ-ын үр өгөөжийг тодорхой харуулах боломжтой байхын тулд ЧХБ-ын тогтолцоо нь уян хатан арга замаар хэрэгждэг байна.

#### 2.3 Хэрэгжүүлэх үйл явц

*Стандарт:*

Чанарын хөндлөнгийн баталгаажуулалтын үйл явц нь баталгаатай, ач холбогдолтой, урьдчилан тодорхойлсны дагуу тууштай хэрэгжиж, мэдээлэгддэг байна. Үйл явц нь дараах

бүрдэлтэй байна. Үүнд:

- Өөрийн үнэлгээ эсвэл үүнтэй адил
- Хөндлөнгийн үнэлгээ, үүнд шинжээч сургуульд очиж ажиллах
- Хөндлөнгийн үнэлгээний тайлан
- Дараагийн сайжруулах үйл ажиллагаа

*Заавар зөвлөгөө:*

Мэргэжлийн, нийцтэй, ил тод хэрэгжсэн ЧХБ хүлээн зөвшөөрөгдөж, үр нөлөөтэй байдаг.

ЧХБ-ын тогтолцооны загвараас хамааран сургууль өөрийн үнэлгээ, эсвэл өөр хэлбэрээр баримт нотолгоо цуглуулж ЧХБ-нд бэлтгэдэг. Эдгээр баримт материал нь шинжээч сургуульд ажиллах үеэр оролцогч талуудтай хийх ярилцлагаар ихэвчлэн нэмэгдэж, бүрддэг. Хөндлөнгийн шинжээчдийн багийн бичсэн тайланд уг үнэлгээгээр цуглуулсан мэдээллийг нэгтгэн дүгнэнэ (стандарт 2.4-2.5 үз).

Шинжээчид тайлангаа бичсэнээр хөндлөнгийн үнэлгээ дуусахгүй. Шинжээчдийн тайлан нь сургуулийн үйл ажиллагааны заавар зөвлөгөө болдог. Заавар зөвлөгөөийн дагуу сургуулийн авах арга хэмжээг ЧББ тохирох үйл явцын дагуу гүйцэтгэлийг хянадаг. Хэрхэн хянах нь ЧХБ-ын тогтолцооны загвараас хамаардаг.

## 2.4 Шинжээчдийн үнэлгээ

*Стандарт:*

Суралцагчийн төлөөллийг оролцуулсан хөндлөнгийн шинжээчдийн баг чанарын хөндлөнгийн баталгаажуулалтыг хийнэ.

*Заавар зөвлөгөө:*

ЧХБ-ын гол цөм нь ДБСБ, профессорууд, оюутан, ажил олгогч буюу мэргэжлийн байгууллага зэрэг янз бүрийн төлөөллөөс бүрдэх, ЧББ-ын үйл хэрэгт хувь нэмрээ оруулагч шинжээчдийн өргөн хүрээний туршлага юм.

Шинжээчдийн ажил нь үнэ цэнэ, ач холбогдолтой байх үүднээс, шинжээчид нь:

- Нарийвчлан сонгон шалгаруулсан байх
- Зохих ур чадвар, шинжээчийн үүргийн гүйцэтгэх чадамжтай байх
- Шаардлагатай сургалт болон мэдээллээр хангагдсан байх

ЧББ нь ашиг сонирхолын зөрчилгүй байх механизмыг хэрэгжүүлэх замаар шинжээчдийн хараат бус байдлыг хангасан байна.

ЧХБ-нд, жишээ нь шинжээчдийн багт олон улсын шинжээч оролцуулах нь үйл явцын хэрэгжилт, хөгжлийг цаашид улам нэмэгдүүлдэг.

## 2.5 Үр дүнгийн шалгуур

*Стандарт:*

Чанарын хөндлөнгийн баталгаажуулалтын эцэст гарч буй дүгнэлт, үр дүн нь олон нийтэд мэдээлэгдсэн, тодорхой шалгуурт үндэслэсэн байх ба албан ёсны шийдвэр гаргах эсэхээс үл хамааран тууштай хэрэглэнэ.

*Заавар зөвлөгөө:*



ЧХБ, ялангуяа түүний үр дүн нь үнэлгээ, дүгнэлт хийлгэж буй сургууль, хөтөлбөрт мэдэгдэхүйц үр нөлөө үзүүлдэг байх ёстой.

Найдвартай, тэнцвэртэй байх сонирхолын үүднээс ЧХБ-ын үр дүн нь урьдчилан тодорхойлж, мэдээлсэн шалгуурт үндэслэх бөгөөд шалгуур нь нийцтэй тайлбар, баримтанд суурилсан байна. ЧХБ-ын тогтолцооноос хамааран үр дүн нь заавар зөвлөгөө, дүгнэлт, албан ёсны шийдвэр гэх мэт өөр өөр хэлбэртэй байж болно.

## 2.6 Тайлагнал

*Стандарт:*

Шинжээчдийн бүрэн тайлан нь хэвлэгдэхээс гадна эрдмийн хамт олон, хөндлөнгийн түншлэгч, бусад сонирхсон хүмүүст тодорхой, ойлгомжтой байна. Хэрвээ тайланд үндэслэн чанарын баталгаажуулалтын байгууллага албан ёсны шийдвэр гаргадаг бол шийдвэрийг тайлантай хамт мэдээлдэг байна.

*Заавар зөвлөгөө:*

Шинжээчдийн тайлан нь хөндлөнгийн үнэлгээний мөрөөр хийх үйл ажиллагааны үндэслэл болохын зэрэгцээ сургуулийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг нийгэмд хүргэдэг. Тайлан нь цаашид хийх үйл ажиллагааны үндэслэл болохын хувьд бүтэц, хэл найруулгын хувьд тодорхой, товч бичигдсэн байх ба дараах зүйлсийг багтаасан байна. Үүнд:

- Агуулгын тодорхойлолт (ДБСБ өөрийн онцлог нөхцөл байдлыг тодорхойлоход туслах)
- Шинжээчийн үйл ажиллагааны горим, журмын тодорхойлолт
- Баримт, дүн шинжилгээ, дүгнэлт
- Нэгдсэн дүгнэлт
- Сургуулийн хэрэгжүүлсэн сайн туршлагын онцлог
- Цаашдын үйл ажиллагаанд зориулсан заавар зөвлөгөө

Товч тайлан бэлтгэх нь үр дүнтэй байж болно.

Тайланг эцэслэн гаргахаас өмнө баримтын алдааг нягтлах боломжийг сургуульд олгох нь тайлангийн үнэн зөв, бодит байдлыг илүү сайжруулдаг.

## 2.7 Гомдол мэдүүлэх ба давж заалдах

*Стандарт:*

Гомдол мэдүүлэх ба шийдвэрлэх үйл явц нь чанарын хөндлөнгийн баталгаажуулалтын тогтолцооны нэг хэсэг болж ойлгомжтой тодорхойлогдсон байх ба сургуулиудад мэдээлсэн байна.

*Заавар зөвлөгөө:*

Сургуулийн эрхийг хамгаалах, шударга шийдвэр гаргах үүднээс ЧХБ нь ил тод, хариуцлагатай хэрэгждэг байна. Гэхдээ энэ үйл явц болон албан ёсны үр дүнгийн талаар сэтгэл дундуур байх тохиолдол эсвэл ташаа ойлголт байж магадгүй юм.

ЧББ-тай холбоотой асуудлыг шийдэх үйл явцад сургуулиуд оролцох боломжийг олгох хэрэгтэй. ЧББ ийм асуудлыг тодорхой, тууштай хэрэгжих, мэргэжлийн арга замаар шийдвэрлэдэг байна.

Гомдол мэдүүлэх журам нь сургуулийг ЧХБ-ын үйл явцын гүйцэтгэл эсвэл гүйцэтгэсэн этгээдэд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлэх боломжийг олгодог.

Давж заалдах журамд сургууль албан ёсны үр дүнгийн талаар, үүнд үнэлгээний үр дүн нь тохирох баримт нотолгоонд үндэслээгүй, шалгуурыг зөв хэрэглээгүй, үнэлгээний үйл явц нь тууштай хэрэгжээгүй талаар асуудлыг тусгадаг.

### 3 ДУГААР БҮЛЭГ.

#### ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СТАНДАРТ БА ЗААВАР ЗӨВЛӨГӨӨ

##### 3.1 Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа, бодлого, үйл явц

*Стандарт:*

Чанарын баталгаажуулалтын байгууллага нь энэхүү ЧБСЗЗ-нүүдийн 2 дугаар бүлэгт тодорхойлсон чанарын хөндлөнгийн баталгаажуулалтын үйл ажиллагааг тогтмол явуулдаг байна. Чанарын баталгаажуулалтын байгууллага нь олон нийтэд нээлттэй байгаа эрхэм зорилгынхоо бүрэлдэхүүн болох ил тод, ойлгомжтойгоор тунхагласан зорилго, зорилттой байна. Эдгээр зорилго, зорилт нь тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтэрсэн байна. Чанарын баталгаажуулалтын байгууллага нь засаглал болон үйл ажиллагаандаа оролцогч талуудын оролцоог хангасан байна.

*Заавар зөвлөгөө:*

ЧХБ-ыг ихээхэн ач холбогдолтой байлгах нь сургууль болон ЧББ-ын талаарх олон нийтийн итгэлд чухал байдаг.

Иймд чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааны зорилго, зорилтыг ЧББ болон дээд боловсролын салбар дахь оролцогч талууд, түүний дотроос ДБСБ хоорондын уялдаа холбоо, ЧББ-ын үйл ажиллагааны цар хүрээний хамт тодорхойлж, мэдээлсэн байна. ЧББ-ын хороодод олон улсын гишүүдийг оруулснаар байгууллагын мэргэшлийн чадавхийг нэмэгдүүлж болно.

Харилцан адилгүй зорилго, зорилтоос хамааран ЧББ-уудын явуулж буй ЧХБ-ын үйл ажиллагаа өөр өөр байж болно. Түүний дотор байгууллага, хөтөлбөрийн түвшинд хийх дүгнэх үнэлгээ /evaluation/, дүн шинжилгээ /review/, аудит /audit/, үнэлгээ /assessment/, магадлан итгэмжлэл /accreditation/, түүнчлэн эдгээртэй адилтгах үйл ажиллагаа нь мөн өөр өөрөөр хэрэгжиж болно. ЧББ нь өөр бусад үйл ажиллагааг явуулж байгаа бол ЧХБ болон бусад үйл ажиллагааны ялгаа, зааг тодорхой байх шаардлагатай.

##### 3.2 Албан ёсны статус

*Стандарт:*

Чанарын баталгаажуулалтын байгууллагыг хуульзүйн хүрээнд байгуулсан байхаас гадна олон нийтийн эрх бүхий байгууллагаас чанарын баталгаажуулалтын байгууллага хэмээн албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байна.

*Заавар зөвлөгөө:*

Ялангуяа ЧХБ-ыг зохицуулах зорилгоор хийж байгаа бол үйл явцын үр дагаварын найдвартай байдал нь дээд боловсролын салбар, төр, оролцогч талууд, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байна.

### 3.3 Хараат бус байдал

*Стандарт:*

Чанарын баталгаажуулалтын байгууллага нь хараат бус байх ба бие даан үйл ажиллагаа явуулна. Тухайн байгууллага нь гуравдагч талын нөлөөгүйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх ба үйл ажиллагаа, түүний үр дагаварт бүрэн хариуцлага хүлээдэг байна.

*Заавар зөвлөгөө:*

Бие даасан ДБСБ хараат бус ЧББ-тай түншлэнэ.

ЧББ-ын хараат бус байдалд дараах зүйлс чухал. Үүнд:

- Байгууллагын хараат бус байдал: Албан ёсны баримт бичиг (үүнд: засгийн газрын болон хууль эрхзүйн баримт бичиг, байгууллагын дүрэм, журам г.м.)-т ЧББ-ын үйл ажиллагаа нь ДБСБ, засгийн газар, бусад оролцогч тал гэх зэрэг гуравдагч талаас ангид хараат бус байна гэж заасан байна.
- Үйл ажиллагааны хараат бус байдал: ЧББ-ын журам, аргагүйг батлан хэрэгжүүлэх, түүнчлэн хөндлөнгийн шинжээчийг нэр дэвшүүлэх, томилох нь ДБСБ, засгийн газар, бусад оролцогч талууд зэрэг гуравдагч талаас ангид хараат бусаар хийгддэг байна.
- Албан ёсны шийдвэрийн хараат бус байдал: холбогдох оролцогч талууд, тэр дундаа суралцагчийн төлөөллөөс бүрдсэн шинжээчдийн баг нь чанарын баталгаажууллын үйл явцын нэг хэсэг боловч эцсийн үр дагаварыг ЧББ-ын хариуцна.

ЧББ-ын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах хүн, тухайлбал шинжээчийг гуравдагч талаас нэр дэвшүүлж болох боловч тэд хувийн чадавхиараа ажиллах бөгөөд ЧББ-д ажиллахдаа томилогдсон /сонгогдсон/ байгууллагаа төлөөлөхгүй. Ямар ч журам, шийдвэр нь мэргэжлийн мэдлэг, туршлагад суурилсан байх нь хараат бус байдлыг хангахад чухал байдаг.

### 3.4 Нарийвчилсан дүн шинжилгээ

*Стандарт:*

Чанарын баталгаажуулалтын байгууллага нь хэрэгжүүлж буй чанарын хөндлөнгийн баталгаажуулалтын үйл ажиллагааны ерөнхий мэдээллийг нарийвчлан тайлбарлаж, дүн шинжилгээ хийсэн тайланг олон нийтэд тогмтол мэдээлдэг байна.

*Заавар зөвлөгөө:*

ЧББ нь үйл ажиллагааныхаа явцад сургууль болон хөтөлбөрийн талаар олж цуглуулсан мэдээллийг дан ганц чанарын баталгаажуулалтад ашиглахаас гадна дээд боловсролын салбарыг бүхэлд нь хамарсан бүтцийн дүн шинжилгээний материал болгон ашиглах боломжтой. Эдгээр цуглуулсан мэдээлэл нь ДБСБ-ын, үндэсний, олон улсын төвшинд чанарын баталгаажуулалтын бодлого, үйл явцыг сайжруулахад хувь нэмрээ оруулах ач холбогдолтой байдаг.

Мэдээлэлд нарийн, нухацтай дүн шинжилгээ хийх нь хөгжил, чиг хандлага, сайн туршлагыг мөн түгээмэл хүндрэл бэрхшээлийг нээн харуулдаг.

### 3.5 Нөөц

*Стандарт:*

Чанарын баталгаажуулалтын байгууллага өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүний болон санхүүгийн хангалттай, хүртээмжтэй нөөцтэй байна.

*Заавар зөвлөгөө:*

ЧББ нь хангалттай, зохистой санхүүжилттэй, нийгмийн болон хувь хүний хөгжилд дээд боловсрол чухал үр нөлөөтэй байх нь олон нийтийн ашиг сонирхолд нийцдэг. Нөөц нь ЧББ ЧХБ-ын үйл ажиллагааг үр дүнтэй, үр өгөөжтэй хэлбэрээр зохион байгуулж, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Түүнчлэн нөөц нь ЧББ өөрийн үйл ажиллагаагаа сайжруулах, олон нийтэд үйл ажиллагааныхаа талаар мэдээлэх боломжийг олгодог.

### **3.6 Чанарын дотоод баталгаажуулалт ба мэргэжлийн ёсзүй**

*Стандарт:*

Чанарын баталгаажуулалтын байгууллага үйл ажиллагааныхаа нэгдмэл байдал, чанарыг тодорхойлох, баталгаажуулах, бэхжүүлэхэд чиглэсэн чанарын дотоод баталгаажуулалтын үйл явцыг хэвшүүлсэн байна.

*Заавар зөвлөгөө:*

ЧББ оролцогч талуудынхаа өмнө хариуцлага хүлээх ёстой. Иймд ЧББ-ын үйл ажиллагаанд мэргэжлийн өндөр стандарт болон нэгдмэл байдал зайлшгүй шаардлагатай юм. Өөрийн үйл ажиллагааг үнэлж дүгнэн, засан сайжруулах нь тогтмол хийгдснээр ДБСБ болон нийгэмд үзүүлэх ажил, үйлчилгээгээ илүү тохиромжтой болгох юм.

ЧББ нь ЧДБ-ын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх ба вебсайтаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ. Энэхүү бодлого нь:

- ЧББ-ын үйл ажиллагаанд оролцож буй бүх хүмүүс нь шаардлага хангасан, мэргэжлийн өндөр ур чадвартай, ёсзүйтэй ажиллах баталгаа
- ЧББ доторх байнгын хөгжилд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн санал бодол, хүсэлтийн механизмыг агуулсан байх
- Бүх төрлийн үл тэвчих, ялгаварлан гадуурхахын эсрэг байх зарчмыг сахих
- Үйл ажиллагаа явуулж буй улс орны эрх бүхий байгууллагуудтай зохистой харилцаа холбоотой байх
- Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг бүхэлд нь болон зарим хэсгийг гэрээгээр бусад талуудаар гүйцэтгүүлдэг бол гэрээлэгч талаар гүйцэтгүүлж буй үйл ажиллагаа, тэдний нийлүүлсэн бүтээгдэхүүн нь энэхүү ЧБСЗЗ-үүдэд нийцсэн байх
- ЧББ нь ДБСБ-ын ЧХБ-ын статус, хүлээн зөвшөөрөх байдлыг тогтоодог байх

### **3.7 Давтамжит хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байх**

*Стандарт:*

ЧБСЗЗ-д нийцэж буйгаа батлахын тулд чанарын баталгаажуулалтын байгууллага нь 5 жилд нэгээс доошгүй удаа хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байна.

*Заавар зөвлөгөө:*

Давтамжит хөндлөнгийн үнэлгээ нь ЧББ-ыг өөрийн бодлого, үйл ажиллагаагаа эргэцүүлэн хянахад нь тусладаг. Энэ нь ЧБСЗЗ-д заасан зарчмуудыг цаашид дагаж мөрдөх боломжийг ЧББ болон түүний оролцогч талуудад олгодог.

## **ХАВСРАЛТ: СТАНДАРТЫН ХУРААНГУЙ ЖАГСААЛТ**

### **Бүлэг 1: ЧАНАРЫН ДОТООД БАТАЛГААЖУУЛАЛТЫН СТАНДАРТ**

#### **1.1. Чанарын баталгаажуулалтын бодлого**

ДБСБ нь стратеги удирдлагынхаа нэг хэсэг болох чанарын баталгаажуулалтын бодлоготой, түүнийгээ олон нийтэд мэдээлдэг байна. Дотоод оролцогч талууд зохих бүтэц, үйл явцаар дамжуулан энэхүү бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцдог байхаас гадна хөндлөнгийн оролцогч талуудын оролцоог хангадаг байна.

#### **1.2. Хөтөлбөр боловсруулах ба батлах**

Дээд боловсролын сургалтын байгууллага нь хөтөлбөр боловсруулах, батлах үйл явцтай байна. Хөтөлбөрийг суралцахуйн зорилтот үр дүнг агуулан тодорхойлсон зорилгод нийцэхүйц боловсруулах шаардлагатай. Хөтөлбөрийн үр дүнд эзэмших мэргэшлийг тодорхой заасан, тэр нь дээд боловсролын мэргэшлийн үндэсний хүрээ, мөн Европын дээд боловсролын оройн зайн боловсролын мэргэшлийн хүрээний зохих төвшинд нийцсэн, харилцан уялдсан байна.

#### **1.3. Суралцагч төвтэй суралцахуй, багшлахуй ба үнэлгээ**

Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцахуйн үйл явцад суралцагчийн идэвхитэй оролцоог дэмжих арга замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх бөгөөд суралцагчийн үнэлгээ нь мөн ижил хандлагатай байна.

#### **1.4. Суралцагч элсэх, ахиж дэвших, хүлээн зөвшөөрөгдөх, гэрчилгээ авах**

Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн “амьдралын мөчлөг”-ийн бүх үе шат /элсэх, ахиж дэвших, хүлээн зөвшөөрөх, гэрчилгээ авах г.м./-ыг хамруулсан урьдчилан тодорхойлж, мэдээлсэн журмуудыг байнга дагаж мөрдөнө.

#### **1.5. Багшлах бүрэлдэхүүн**

Дээд боловсролын сургалтын байгууллага нь багш нарынхаа чадамжийг өөрөө баталгаажуулна. Багшийг сонгон шалгаруулж ажилд авах, хөгжүүлэх үйл явц нь шударга, ил тод байна.

#### **1.6. Суралцахуйн нөөц ба суралцагчийн дэмжлэг**

Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцахуй болон багшлахуйн ажилд зориулсан санхүүжилт, суралцахуйн хангалттай, хүртээмжтэй нөөцтэй байх ба оюутныг дэмждэг байна.

#### **1.7. Мэдээллийн удирдлага**

Дээд боловсролын сургалтын байгууллага өөрийн хөтөлбөр, бусад үйл ажиллагааг үр дүнтэй удирдахын тулд холбогдох мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, ашиглах боломжийг хангасан байна.

#### **1.8. Олон нийтийн мэдээлэл**

Дээд боловсролын сургалтын байгууллага нь хөтөлбөр, бусад үйл ажиллагааны мэдээллийг хэвлэн түгээдэг байна. Мэдээлэл нь тодорхой, үнэн зөв, бодитой байх ба олж авахад хялбар, байнга шинэчлэгддэг байна.

#### **1.9. Хөтөлбөрийн байнгын хяналт-шинжилгээ болон үечилсэн үнэлгээ**

Хөтөлбөрүүд нь тодорхойлсон зорилгодоо хүрэх, суралцагч болон нийгмийн хэрэгцээг хангахын тулд сургууль нь хяналт-шинжилгээ, үечилсэн үнэлгээ хийдэг байна. Шинжилгээ, үнэлгээ нь хөтөлбөрүүдийг тасралтгүй сайжруулахад чиглэнэ. Үүнтэй холбоотой төлөвлөсөн үйл ажиллагаа болон хүрсэн үр дүн нь холбогдох бүх талууд, хүмүүст мэдээлэгддэг байна.

#### **1.10. Чанарын хөндлөнгийн давтамжит баталгаажуулалт**

Дээд боловсролын сургалтын байгууллага нь энэхүү ЧБСЗЗ-д нийцүүлэн чанарын хөндлөнгийн баталгаажуулалтыг давтамжит байдлаар хийлгэнэ.

### **Бүлэг 2: ЧАНАРЫН ХӨНДЛӨНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН СТАНДАРТ**

#### **2.1. Чанарын дотоод баталгаажуулалтыг чухалчлах**

Чанарын хөндлөнгийн баталгаажуулалт нь энэхүү ЧБСЗЗ-ийн 1 дүгээр бүлэгт заасан чанарын дотоод баталгаажуулалтын үр өгөөжийг авч үздэг байна.

#### **2.2. Зорилгод нийцсэн арга зүйг боловсруулах**

Зорилго, зорилтдоо хүрэх боломжийг хангахаар холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн чанарын хөндлөнгийн баталгаажуулалтыг тодорхойлж, боловсруулсан байна. Ийнхүү боловсруулах, тасралтгүй сайжруулахад оролцогч талууд оролцдог байна.

#### **2.3. Хэрэгжүүлэх үйл явц**

Чанарын хөндлөнгийн баталгаажуулалтын үйл явц нь баталгаатай, ач холбогдолтой, урьдчилан тодорхойлсны дагуу тууштай хэрэгжиж, мэдээлэгддэг байна. Үйл явц нь дараах бүрдэлтэй байна. Үүнд:

- Өөрийн үнэлгээ эсвэл үүнтэй адил
- Хөндлөнгийн үнэлгээ, үүнд шинжээч сургуульд очиж ажиллах
- Хөндлөнгийн үнэлгээний тайлан
- Дараагийн сайжруулах үйл ажиллагаа

#### **2.4. Шинжээчдийн үнэлгээ**

Суралцагчийн төлөөллийг оролцуулсан хөндлөнгийн шинжээчдийн баг чанарын хөндлөнгийн баталгаажуулалтыг хийнэ.

#### **2.5. Үр дүнгийн шалгуур**

Чанарын хөндлөнгийн баталгаажуулалтын эцэст гарч буй дүгнэлт, үр дүн нь олон нийтэд мэдээлэгдсэн, тодорхой шалгуурт үндэслэсэн байх ба албан ёсны шийдвэр гаргах эсэхээс үл хамааран тууштай хэрэглэнэ.

#### **2.6. Тайлагнал**

Шинжээчдийн бүрэн тайлан нь хэвлэгдэхээс гадна эрдмийн хамт олон, хөндлөнгийн түншлэгч, бусад сонирхсон хүмүүст тодорхой, ойлгомжтой байна. Хэрвээ тайланд үндэслэн чанарын баталгаажуулалтын байгууллага албан ёсны шийдвэр гаргадаг бол шийдвэрийг тайлантай хамт мэдээлдэг байна.

#### **2.7. Гомдол мэдүүлэх ба давж заалдах**

Гомдол мэдүүлэх ба шийдвэрлэх үйл явц нь чанарын хөндлөнгийн баталгаажуулалтын тогтолцооны нэг хэсэг болж ойлгомжтой тодорхойлогдсон байх ба сургуулиудад мэдээлсэн байна.

## **Бүлэг 3: ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СТАНДАРТ**

### **3.1. Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа, бодлого, үйл явц**

Чанарын баталгаажуулалтын байгууллага нь энэхүү ЧБСЗЗ-нүүдийн 2 дугаар бүлэгт тодорхойлсон чанарын хөндлөнгийн баталгаажуулалтын үйл ажиллагааг тогтмол явуулдаг байна. Чанарын баталгаажуулалтын байгууллага нь олон нийтэд нээлттэй байгаа эрхэм зорилгынхоо бүрэлдэхүүн болох ил тод, ойлгомжтойгоор тунхагласан зорилго, зорилттой байна. Эдгээр зорилго, зорилт нь тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтэрсэн байна. Чанарын баталгаажуулалтын байгууллага нь засаглал болон үйл ажиллагаандаа оролцогч талуудын оролцоог хангасан байна.

### **3.2. Албан ёсны статус**

Чанарын баталгаажуулалтын байгууллагыг хуульзүйн хүрээнд байгуулсан байхаас гадна олон нийтийн эрх бүхий байгууллагаас чанарын баталгаажуулалтын байгууллага хэмээн албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байна.

### **3.3. Хараат бус байдал**

Чанарын баталгаажуулалтын байгууллага нь хараат бус байх ба бие даан үйл ажиллагаа явуулна. Тухайн байгууллага нь гуравдагч талын нөлөөгүйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх ба үйл ажиллагаа, түүний үр дагаварт бүрэн хариуцлага хүлээдэг байна.

### **3.4. Нарийвчилсан дүн шинжилгээ**

Чанарын баталгаажуулалтын байгууллага нь хэрэгжүүлж буй чанарын хөндлөнгийн баталгаажуулалтын үйл ажиллагааны ерөнхий мэдээллийг нарийвчлан тайлбарлаж, дүн шинжилгээ хийсэн тайланг олон нийтэд тогтмол мэдээлдэг байна.

### **3.5. Нөөц**

Чанарын баталгаажуулалтын байгууллага өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүний болон санхүүгийн хангалттай, хүртээмжтэй нөөцтэй байна.

### **3.6. Чанарын дотоод баталгаажуулалт ба мэргэжлийн ёсзүй**

Чанарын баталгаажуулалтын байгууллага үйл ажиллагааныхаа нэгдмэл байдал, чанарыг тодорхойлох, баталгаажуулах, бэхжүүлэхэд чиглэсэн чанарын дотоод баталгаажуулалтын үйл явцыг хэвшүүлсэн байна.

### **3.7. Давтамжит хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байх**

ЧБСЗЗ-д нийцэж буйгаа батлахын тулд чанарын баталгаажуулалтын байгууллага нь 5 жилд нэгээс доошгүй удаа хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байна.